



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/496

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн, 29.1.3.“а”, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйн салбарт хийгдсэн ажлын талаар нэвтрүүлэг бэлтгэхэд 3.000.000 (гурван сая), Монголын хоолойн тэмээ, Тээлийн улаан ямааны нядалгааны жин, гарц, гулуузны бүтцийг тодорхойлох мөн махны химийн найрлага, чанар, арьсны гистологийн шинжилгээний зардалд 3.100.000 (гурван сая нэг зуун мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх 6.100.000 (зургаан сая нэг зуун мянга) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101054